



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 4/108

Улаанбаатар хот

Г

Г

Журам батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, захиргааны зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн “Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулах түүнийг хэрэгжүүлэх, дүгнэх журам”-ыг хавсралт 1-ээр баталж, 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү журмыг баталсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 490 тоот тушаалын хавсралт 2-оор баталсан “Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Баталсан журмыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инноваци, гадаад харилцааны асуудал хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

Захирлын 2018 оны 09 дугаар сарын 01 -ны  
өдрийн 01 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

1117144746  
УХД0072 9104399

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ,  
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ

НЭГ. ЖУРМЫН ЗОРИЛГО

1.1 Энэ журмын зорилго нь Монгол Улсын Их Сургууль /цаашид МУИС гэх/-ийн 2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд тусгагдсан гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхтэй холбогдсон хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх болон дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ЖУРАМ ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

2.1 Энэ журам нь МУИС-ийн гадаад харилцааны хүрээнд оюутан суралцуулах, багш, судлаач ажиллуулах, хамтарсан судалгааны ажил, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, багш оюутан солилцох, эрдэм шинжилгээний бүтээл солилцох, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулахад үйлчилнэ.

2.2 Энэхүү журмаар зохицуулагдаагүй холбогдох асуудлыг МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

ГУРАВ. ҮНДСЭН ЗАРЧИМ

3.1 МУИС бие дааж болон гадаадын их дээд сургууль, байгууллагын харилцан ашигтай, бие даасан байдлыг хүндэтгэх зарчимд үндэслэн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

3.2 Хамтын ажиллагааны гэрээ байгуулах талууд хоёр улсын Дээд боловсролын салбарын холбогдох хууль тогтоомж, тухайн байгууллагын дотоод журмыг баримтална.

3.3 МУИС-ийн хамтын ажиллагааны гэрээг байгуулахад Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, МУИС-ийн дүрэм, МУИС-ийн сургалтын журам, МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам, МУИС-ийн Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам зэрэг хууль тогтоомжийг баримтална.

ДӨРӨВ. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ САНАЛ ИРҮҮЛЭХ,  
ШИЙДВЭР ГАРГАХ

4.1 Доор дурьдсан байгууллага, багш, ажилтан, албан тушаалтууд хамтын ажиллагааны гэрээ байгуулах санал болон сонирхлоо илэрхийлж болно. Үүнд:

МУИС-ийн үндсэн болон бүтцийн нэгж

- МУИС-ийн удирдлага
- Гэрээ байгуулах сонирхлоо илэрхийлсэн аль нэг улсын их дээд сургууль, институт, байгууллага

4.2 МУИС-ийн Гадаад харилцааны хэлтэс (цаашид ГХХ гэх) гадаадын их дээд сургууль, байгууллагаас ирүүлсэн саналыг хүлээн авах ба тухайн байгууллагын товч танилцуулга, гэрээний нөхцөл, хамтын ажиллагааны үр дүнгийн талаар мэдээ, тайланг бэлтгэж Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

4.3 МУИС-ийн бүрэлдэхүүн ба салбар сургуулиуд сургууль хоорондын гэрээ байгуулах санал гаргах тохиолдолд тус гэрээг байгуулах үндэслэл, сургуулийн товч танилцуулга, хүлээгдэж буй үр дүнгийн талаарх мэдээ, тайланг ГХХ-т ирүүлэх бөгөөд уг гэрээний саналыг ажлын 30 хоногийн дотор Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж олонхийн саналын үндсэн дээр шийдвэрлэнэ.

4.4 МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль, тэнхим, профессор хооронд гэрээ байгуулах саналыг тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн удирдлага Захиргааны зөвлөл, тэнхимиийн хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд энэ тухайгаа ГХХ-т мэдээлнэ.

4.5 МУИС-д хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх хамтарсан төсөл хөтөлбөрийн хүрээнд тухайн төсөл хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангахын тулд МУИС болон төсөлд оролцогч талуудын хооронд гэрээ байгуулах эсэх талаар Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

**ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ,  
ГЭРЭЭНИЙ АГУУЛГА**

5.1 Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ дараах үндсэн агуулгатай байна. Үүнд:

- Хоёр сургуулийн хооронд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны төрөл хэлбэрүүд /багш солилцоо, оюутан солилцоо, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ном сурах бичиг солилцох, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх г.м/
- Гэрээний хүчинтэй хугацаа
- Талуудын албан ёсны хаяг, цахим шуудангийн хаяг, вэбсайт
- Гэрээ дуусгавар болох хугацаа

**ЗУРГАА. ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ,  
БАТАЛГААЖУУЛАХ, АРХИВЛАХ**

6.1 Гэрээний төсөл, танилцуулга, үндэслэл үр дүнгийн тухай товч тайланг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, МУИС-ийн захирал гарын үсэг зурж баталгаажуулах тухай эцсийн шийдвэрийг Захиргааны зөвлөл гаргана.

6.2 Шаардлагатай тохиолдолд хамтын ажиллагааны гэрээг хариуцах этгээдийг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж томилно.

6.3 Гэрээг шуудангаар солилцож зурах эсхүл гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг зохион байгуулах хэлбэрээр байгуулж, баталгаажуулна.



6.4 Баталгаажсан гэрээг эх хувиар ГХХ хариуцаж хадгалах бөгөөд гэрээний цахим архивт ажлын 7 хоногийн дотор байрлуулсан байна.

6.5 ГХХ хамтын ажиллагааны гэрээ байгуулсан сургуулиудын мэдээллийг сургуулийн вэб сайтад тухай бүрт оруулна.

6.6 Бүрэлдэхүүн ба салбар сургуулиуд гадаадын их дээд сургуулиудтай гэрээ байгуулах тохиолдолд тухайн бүрэлдэхүүн ба салбар сургуулийн Эрдмийн зөвлөл эсхүл Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж гэрээг баталгаажуулна.

6.7 Бүрэлдэхүүн ба салбар сургуулиуд гарын үсэг зурж баталгаажсан гэрээг эх хувиар нь хадгалах ба гэрээний хувийг ГХХ цахим хэлбэрээр ирүүлж, цахим архивт бүртгүүлнэ.

#### ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

7.1 МУИС-ийн гадаад хамтын ажиллагаанд онцгой үүрэгтэй стратегийн ач холбогдол бүхий хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсаны дараа гэрээг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрдэм шинжилгээ, инноваци, гадаад харилцааны асуудал хариуцсан дэд захирал томилно.

7.2 Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гэрээний нөхцөлийг хэрэгжүүлэхэд холбогдолтой сургалт, судалгаа, мэргэжлийн чиглэлээр ажиллах багш, ажилтныг томилон ажиллуулна.

7.3 Ажлын хэсэг нь гэрээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж холбогдох газар, хэлтэс, бүрэлдэхүүн сургуультай хамтран гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулна.

7.4 Ажлын хэсэг нь гэрээний хэрэгжилтийн явцыг жил бүр дүгнэн МУИС-ийн удирдлагуудад танилцуулна.

7.5 Журмын 7.1-д зааснаас бусад гэрээний хэрэгжилтийг ГХХ хангах бөгөөд жил бүр гадаад хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн явцад дүгнэлт хийж, авсан арга хэмжээний талаар Захиргааны Зөвлөлд мэдээлэл хийнэ.

7.6 ГХХ-ээс хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилттэй холбоотой зардлыг Санхүү эрхэлсэн дэд захиралд танилцуулж санхүүгийн төлөвлөгөөнд оруулах бөгөөд сургуулийн болон бүрэлдэхүүн сургуулийн төсөвт суулгаж баталгаажуулна.

#### НАЙМ. ГЭРЭЭГ СУНГАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

8.1 Гадаадын их дээд сургуулиас ирүүлсэн хамтын ажиллагааны гэрээг сунгах, дуусгавар болгох саналыг Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

8.2 Хамтын ажиллагааны гэрээний хугацаа дуусгавар болох үед гэрээний нөгөө талд мэдэгдэж сунгах талаар харилцан санал солилцож, гэрээний үр дүнгийн тухай тайланг Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж олонхийн саналыг үндэслэн цаашид гэрээг үргэлжлүүлэн сунгах эсхүл дуусгавар болгох шийдвэрийг гаргуулна.

8.3 ГХХ тус шийдвэрийг үндэслэн тухайн санал ирүүлсэн гадаадын их дээд сургуульд бичгээр хариу мэдэгдэнэ.

ЕС. БУСАД


9.1 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт, өөрчлөлтийг үндсэн гэрээнд бичгээр оруулсан нөхцөлд уг өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба талуудын аль нэг нь уг гэрээний үүргээс татгалзахгүй болно.

9.3 Хамтын ажиллагааны гэрээний хэл англи хэл байх бөгөөд тухайн орны хэл дээр хийгдсэн тохиолдолд хоёр дахь хувийг монгол хэл дээр үйлдэнэ.

9.4 Гэрээтэй холбогdon гарсан аливаа маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол улсын болон олон улсын арбитраар шийдвэрлүүлнэ.

xxx



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2011 оны 09 сарын 27 өдөр


Дугаар 490

Улаанбаатар хот

Журам батлах тухай

МУИС-ийн дүрмийн 2.1, 3.2, 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж сайшаагдсан “МУИС-д эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.



Захирлын 2011 оны 9 сарын .....ны  
өдрийн 20 тоот тушаалын хавсралт 2

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Их Сургууль /цаашид МУИС гэх/-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, гадаад харилцааг бүс нутагт зорилтод үйл ажиллагаагаар хөгжүүлэх, МУИС-ийн 2020 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.
2. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн захирал шийдвэр гаргана.

### Хоёр. Гэрээ байгуулах санал ирүүлэх, шийдвэр гаргах

3. Доор дурьдсан байгууллага, багш ажилтан, албан тушаалтнууд хамтын ажиллагааны гэрээ байгуулах санал болон сонирхолоо илэрхийлж болно.  
Үүнд:

- МУИС-ийн үндсэн болон бүтцийн нэгж
- МУИС-ийн удирдлага
- Гэрээ байгуулах сонирхолоо илэрхийлсэн аль нэг улс орны их дээд сургууль, институт, гадаад, дотоодын байгууллага

- 3.1. Гадаад, дотоодын байгууллагаас ирсэн саналыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс (ГХХАХ) тухайн байгууллагын товч танилцуулга болон гэрээ байгуулах үндэслэл, хүлээгдэж буй үр дүнгийн талаарх товч илтгэлийг бэлтгэн Захиргааны зөвлөлд оруулж хэлэлцүүлнэ.
- 3.2. Захиргааны зөвлөлөөс МУИС-ийн нэрийн өмнөөс байгуулах шаардлагагүй гэрээ гэж үзвэл холбоо хамааралтай аль нэг бүрэлдэхүүн сургуульд шилжүүлж болно.
- 3.3. Бүрэлдэхүүн ба салбар сургуулиуд гэрээ байгуулах санал гаргах тохиолдолд уг гэрээг байгуулах үндэслэл, сургуулийн товч танилцуулга, хүлээгдэж буй үр дүнгийн талаарх товч илтгэлийг бэлтгэн ГХХАХ-т ирүүлэх бөгөөд уг гэрээг байгуулах үндэслэлтэй гэж үзвэл ГХХАХ-зэс 30 хоногийн дотор Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 3.4. МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын 2-3-тай нь факультет хоорондын гэрээтэй гадаад, дотоодын байгууллага, их дээд сургуультай МУИС-ийн нэрийн өмнөөс хамтын ажиллагааны гэрээг байгуулж болно.

## **Гурав. Гэрээнд гарын үсэг зурах, баталгаажуулах, архивлах**

4. Гэрээний төсөл, танилцуулга, үндэслэл үр дүнгийн тухай товч илтгэлийг Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн гарын үсэг зурах шийдвэрийг Захиргааны зөвлөл гаргана. МУИС-ийн захирал эсвэл ордох албан тушаалтууд гэрээнд гарын үсэг зурна.
5. Шаардлагатай тохиолдолд гэрээнд хариуцах этгээдийг /liaison officer/ томилно.
6. Гэрээг шуудангаар солилцож зурах эсвэл гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг зохион байгуулах хэлбэрээр байгуулж, баталгаажуулна.
7. Баталгаажсан гэрээ эх хувиараа ГХХАХ-т хадгалагдах ба гэрээний цахим архивт ажлын 7 хоногийн дотор орсон байна.
8. Бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд гадаадын их дээд сургуультай гэрээ байгуулах тохиолдолд тухайн бүрэлдэхүүн ба салбар сургуулийн эрдмийн зөвлөл эсвэл захирлын зөвлөлөөс шийдвэр гаргаж гэрээг баталгаажуулна.
9. Бүрэлдэхүүн ба салбар сургуулиуд гарын үсэг зурж баталгаажсан гэрээг эх хувиар нь хадгалах ба гэрээг ГХХАХ-т цахим хэлбэрээр ирүүлж, цахим архивт бүртгүүлнэ.

## **Дөрөв. Гэрээг сунгах, дуусгавар болгох**

10. Гадаадын их дээд сургуулиас ирүүлсэн хамтын ажиллагааны гэрээг сунгах, дуусгавар болгох саналыг Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
11. Гэрээний үр дүнгийн тухай тайлан болон цаашид үргэлжлүүлэн сунгах эсвэл дуусгавар болгох үндэслэлийг бичиж Захиргааны зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.
12. Шийдвэрийг үндэслэн ГХХАХ-ээс тухайн санал ирүүлсэн гадаадын их дээд сургуульд бичгээр хариу мэдэгдэнэ.